



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/12/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: www.dalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМГИЙН 20-Р
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.ОЧИРСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,949,402.66</u>	<u>87,047,324.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	650,000.00	515,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	650,000.00	515,000.00
3122	Гадаад валют	650,000.00	515,000.00
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах	650,000.00	515,000.00
33	АВЛАГА	396,600.00	1,146,600.00
335	Бусад авлага	396,600.00	1,146,600.00
3351	Байгууллагаас авах авлага	396,600.00	396,600.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	750,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,902,802.66	85,385,724.40
351	Түүхий эд материал	40,914,259.56	48,838,800.76
35110	Тусгай зориулалттай материал	40,914,259.56	48,838,800.76
354	Хангамжийн материал	33,988,543.10	36,546,923.64
35410	Бичиг хэргийн материал	3,288,000.00	1,078,900.00
35420	Аж ахуйн материал	674,300.00	1,426,750.00
35440	Түлш, шатах тослох материал	1,700,000.00	1,445,000.00
35470	Бусад хангамжийн материал	28,326,243.10	32,596,273.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,840,623,314.64</u>	<u>4,728,093,439.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,840,623,314.64	4,728,093,439.13
392	Биет хөрөнгө	4,471,271,088.07	4,359,007,212.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,400,762,886.00	4,400,762,886.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(144,332,310.96)	(222,203,788.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,157,504.89	105,743,856.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,930,918.52)	(48,821,697.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,479,510.25	169,479,510.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,865,583.59)	(45,953,554.79)
393	Биет бус хөрөнгө	369,352,226.57	369,086,226.53
39301	Програм хангамж	1,330,000.00	1,330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(287,773.43)	(553,773.47)
39303	Бусад биет бус хөрөнгө	368,310,000.00	368,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,916,572,717.30</u>	<u>4,815,140,763.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>56,800.00</u>	<u>56,800.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	56,800.00	56,800.00
413	Өглөг	56,800.00	56,800.00
4136	Бусад өглөг	56,800.00	56,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	56,800.00	56,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,916,515,917.30</u>	<u>4,815,083,963.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,916,515,917.30	4,815,083,963.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	368,310,000.00	368,310,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	368,310,000.00	368,310,000.00

512	Хуримтлагдсан үр дүн	4,548,205,917.30	4,446,773,963.53
51210	Өмнөх үеийн үр дүн	4,548,205,917.30	4,548,205,917.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(101,431,953.77)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,916,572,717.30</u>	<u>4,815,140,763.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,145,742,124.10	1,211,844,753.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,362,024.10	12,969,553.74
120	Нийтлэг татварын бус орлого	120,362,024.10	12,969,553.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,362,024.10	12,969,553.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,614,960.00	516,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	118,747,064.10	12,453,153.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025,380,100.00	1,198,875,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	867,176,400.00	1,062,901,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	867,176,400.00	1,062,901,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,489,400.00	135,973,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,489,400.00	135,973,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,109,149,014.33	1,313,276,707.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,109,149,014.33	1,313,276,707.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,063,028,108.10	1,245,205,548.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,552,359.52	890,781,993.63
210101	Үндсэн цалин	662,119,429.52	690,198,093.00
210102	Нэмэгдэл	-	134,718,500.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,920,000.00
210104	Урамшуулал	59,432,930.00	59,945,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,802,901.29	119,719,400.00
210201	Тэтгэврийн даатгал	59,875,988.87	83,563,567.85
210202	Тэтгэмжийн даатгал	7,043,910.41	9,166,307.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,622,468.40	7,780,142.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,387,384.81	1,740,949.29
210205	Эрүүл мэндийн даатгал	13,873,148.80	17,468,432.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,098,973.96	93,947,386.70
210301	Гэрэл, цахилгаан	14,926,565.96	8,261,378.70
210302	Түлш, халаалт	52,700,000.00	45,305,000.00
210303	Цэвэр, бохир ус	60,472,408.00	40,381,008.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,958,100.00	15,867,541.00
210401	Бичиг хэрэг	2,292,980.00	2,974,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	961,000.00	1,161,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,360.00	6,516,241.00

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,472,760.00	5,215,420.00
2105	Нормативт зардал	65,300.00	176,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,300.00	176,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,148,500.00	2,588,500.00
210604	Урсгал засвар	2,148,500.00	2,588,500.00
2107	Томилолт, зочны зардал	144,300.00	94,600.00
210702	Дотоод албан томилолт	144,300.00	94,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,590,100.00	1,143,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,680,100.00	135,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	910,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,667,573.33	120,886,627.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,013,000.00	315,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,648,200.00	4,455,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,006,373.33	116,116,227.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,120,906.23	68,071,158.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,237,600.00	26,883,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,983,600.00	25,532,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,254,000.00	1,351,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	41,188,058.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	41,188,058.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	36,593,109.77	(101,431,953.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	36,593,109.77	(101,431,953.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,042,205,826.00	1,221,192,232.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,614,960.00	516,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,614,960.00	516,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,614,960.00	516,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,614,960.00	516,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,040,590,866.00	1,220,675,832.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	867,176,400.00	1,062,901,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	867,176,400.00	1,062,901,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,489,400.00	135,973,400.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,489,400.00	135,973,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,210,766.00	21,800,632.78
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	15,210,766.00	21,800,632.78
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,029,585,826.00	1,221,327,232.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,585,826.00	1,221,327,232.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,857,553.77	1,131,455,441.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	720,594,478.52	891,531,993.63
210101	Үндсэн цалин	661,161,548.52	690,948,093.00
210102	Нэмэгдэл	-	134,718,500.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,920,000.00
210104	Урамшуулал	59,432,930.00	59,945,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,802,901.29	119,719,400.00
210201	Тэтгэврийн даатгал	59,875,988.87	84,247,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,043,910.41	8,868,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,622,468.40	7,094,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,387,384.81	1,773,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,873,148.80	17,736,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,378,973.96	93,692,386.70
210301	Гэрэл, цахилгаан	14,926,565.96	8,261,378.70
210302	Түлш, халаалт	49,980,000.00	45,050,000.00
210303	Цэвэр, бохир ус	60,472,408.00	40,381,008.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,345,400.00	15,276,091.00
210401	Бичиг хэрэг	1,089,880.00	560,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	961,000.00	1,161,000.00
210404	Ном, хэвлэл	940,000.00	507,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,360.00	10,503,041.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,183,160.00	2,544,470.00
2105	Нормативт зардал	2,477,100.00	1,250,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,300.00	211,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,376,800.00	1,039,470.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,685,000.00	2,274,500.00
210604	Урсгал засвар	1,685,000.00	2,274,500.00
2107	Томилолт, зочны зардал	144,300.00	94,600.00
210702	Дотоод албан томилолт	144,300.00	94,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,186,800.00	1,143,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,276,800.00	135,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	910,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,242,600.00	6,472,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,013,000.00	315,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,229,600.00	6,157,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,728,272.23	89,871,791.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,844,966.00	48,683,732.78
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	15,210,766.00	21,800,632.78

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,380,200.00	25,532,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,254,000.00	1,351,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	883,306.23	39,967,058.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	883,306.23	39,967,058.67
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,221,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,221,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,620,000.00	(135,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,990,000.00	(135,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(11,340,000.00)	650,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	650,000.00	515,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,310,000.00	4,511,612,807.53	4,879,922,807.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,310,000.00	4,511,612,807.53	4,879,922,807.53
C07	Тайлант үеийн үр дүн	-	36,593,109.77	36,593,109.77
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,310,000.00	4,548,205,917.30	4,916,515,917.30
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	368,310,000.00	4,548,205,917.30	4,916,515,917.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,310,000.00	4,548,205,917.30	4,916,515,917.30
D08	Тайлант үеийн үр дүн	-	(101,431,953.77)	(101,431,953.77)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,310,000.00	4,446,773,963.53	4,815,083,963.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,200,489,700.0	1,158,203,541.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,489,700.0	1,158,203,541.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,173,084,300.0	1,131,320,441.3

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	891,260,000.0	891,531,993.6
21010 1	Үндсэн цалин	514,846,100.0	690,948,093.0
21010 2	Нэмэгдэл	310,548,500.0	134,718,500.6
21010 3	Унаа хоолны хөнгөлөлт	5,920,000.0	5,920,000.0
21010 4	Урамшуулал	59,945,400.0	59,945,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,719,700.0	119,719,400.0
21020 1	Тэтгэврийн даатгал	84,247,300.0	84,247,000.0
21020 2	Тэтгэмжийн даатгал	8,868,100.0	8,868,100.0
21020 3	ҮОМШӨ-ний даатгал	7,094,500.0	7,094,500.0
21020 4	Ажилгүйдлийн даатгал	1,773,600.0	1,773,600.0
21020 5	Эрүүл мэндийн даатгал	17,736,200.0	17,736,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,698,900.0	93,692,386.7
21030 1	Гэрэл, цахилгаан	13,678,900.0	8,261,378.7
21030 2	Түлш, халаалт	60,863,400.0	45,050,000.0
21030 3	Цэвэр, бохир ус	59,156,600.0	40,381,008.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,699,600.0	15,276,091.0
21040 1	Бичиг хэрэг	560,300.0	560,280.0
21040 3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,167,800.0	1,161,000.0
21040 4	Ном, хэвлэл	507,300.0	507,300.0
21040 5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,919,700.0	10,503,041.0
21040 6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,544,500.0	2,544,470.0
2105	Нормативт зардал	1,393,700.0	1,250,970.0
21050 1	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	353,500.0	211,500.0
21050 3	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,040,200.0	1,039,470.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,274,500.0	2,274,500.0
21060 4	Урсгал засвар	2,274,500.0	2,274,500.0
2107	Томилолт, зочны зардал	378,700.0	94,600.0
21070 2	Дотоод албан томилолт	378,700.0	94,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.0	1,008,000.0
21080 2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	1,008,000.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,651,200.0	6,472,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,013,700.0	315,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,637,500.0	6,157,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,405,400.0	26,883,100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,405,400.0	26,883,100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,053,200.0	25,532,100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,352,200.0	1,351,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,200,489,700.0	1,199,256,600.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,062,901,800.0	1,062,901,800.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,062,901,800.0	1,062,901,800.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	135,973,400.0	135,973,400.0
132001	Орон нутгийн төсвөөс	135,973,400.0	135,973,400.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,614,500.0	381,400.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,614,500.0	516,400.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73.0	72.0
620001	Удирдах ажилтан	1.0	-
620002	Гүйцэтгэх ажилтан	46.0	46.0
620003	Үйлчлэх ажилтан	24.0	24.0
620004	Гэрээт ажилтан	2.0	2.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 20-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын захирал Л.Очирсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 12 дугаар сарын 08-наас 2021 оны 02 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн 20-р сургууль нь “Эрүүл биетэй, хүнлэг сэтгэлтэй, асуудлыг шийдвэрлэх чадвартай, дэлхийн Монгол иргэнийг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн бие даасан байдлыг хангаж, удирдлага хувь хүний зохион байгуулалт, менежментийг сайжруулах
- Сургуулийн онцлогт нийцүүлсэн “Сургалтын стандарт хөтөлбөр-хүүхэд бүрийн хөгжил” сургалт арга зүйг эцэг эхийн дэмжлэгтэйгээр зохион байгуулах
- Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, анги удирдсан багш нарын хүүхэдтэй ажиллах арга барилыг сайжруулж, эцэг эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх
- Хүүхдийн өөрөө удирдах байгууллагыг дэмжиж, “Хүүхэд хүүхдээсээ суралцъя” уриан дор нэгдэн хүүхдийн хөгжил төлөвшилд ахиц гаргах
- Эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор хүүхдийг эрүүл аж төрөх зан үйлд сургах.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын

хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Орхон аймгийн 20-р сургууль нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Орхон аймгийн 20-р сургуулийн дотоод хяналтын комисс нь 2020 онд 9 үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж хяналтын хуудасаар үнэлэлт, дүгнэлт өгөн зөрчилтэй асуудлууд дээр зохих арга хэмжээг авч ажилласан байна.

Орхон аймгийн 20-р сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 673,471.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,734.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,211,844.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,118.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101,432.0 мянган төгрөгөөр буюу 2.06 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	650.0	515.0	(135.0)
Авлага	396.6	1,146.6	750.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	74,902.8	85,385.7	10,482.9
Үндсэн хөрөнгө	4,840,623.3	4,728,093.4	(112,529.9)
Нийт хөрөнгө	4,916,572.7	4,815,140.7	(101,432.0)
Өр төлбөр	56.8	56.8	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,916,515.9	4,815,083.9	(101,432.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,916,572.7	4,815,140.7	(101,432.0)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 515.0 мянган төгрөг болж 135.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын баяр болон багш нарын баярыг угтан 3 ахмадад тусламж үзүүлснээс шалтгаалжээ. Энэ нь ахмадын сангийн дансны хуулганы үлдэгдлээр баталгаажиг байна.

Авлага дансны үлдэгдэл 1,146.6 мянган төгрөг болж 750.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдын цалингаас суутгасан 750.0 мянган төгрөгийг хамтын сангийн дансруу шилжүүлэхдээ андуурч 2 удаа гүйлгээ хийснээс шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 85,385.7 мянган төгрөг болж 10,482.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 91,340.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1,447.1 мянган төгрөгийн математикийн хичээлийн хэрэглэгдэхүүн, 3,657.0 мянган төгрөгийн STEAM сургалтын хэрэглэгдэхүүн, 3,762.7 мянган төгрөгийн ном сурах бичгийг Боловсрол соёл урлагийн газраас үнэ төлбөргүй хүлээн авч, 89,724.4 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,728,093.4 мянган төгрөг болж 112,529.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан элэгдэл 116,116.2 мянган төгрөг бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас хуваарилсан 3,586.3 мянган төгрөгийн зөөврийн компьютер нэмэгдсэн ба үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө тайлант онд бүртгэгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 56.8 мянган төгрөг нь өмнөх онд Мастер дизайн ХХК-с авсан бараа үйлчилгээний төлбөр ба тус газрын үйл ажиллагаа явуулж буй хүмүүс нь өөрчлөгдсөний улмаас тооцоо нийлж чадаагүй үлдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,815,083.9 мянган төгрөг болж 101,432.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой.

Орхон аймгийн 20-р сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 66,102.6 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн нь улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Төсөвт байгууллагын өөрийн орлого	120,362.0	12,969.5	(107,392.5)
Улсын төвлөрсөн төсвөөс	867,176.4	1,062,901.8	195,725.4
Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,489.4	135,973.4	7,484.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	29,714.3	0.0	(29,714.3)
Нийт дүн	1,145,742.1	1,211,844.7	66,102.6

Нийт зардал өмнөх оноос 182,177.4 мянган төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь ажиллах хүчний орон тоо

нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн, ковидын хөл хорионоос шалтгаалан сургуулиуд цахимаар хичээллэсэнтэй холбоотой байр ашиглалтын зардал буурсан байна.

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	721,552.36	890,781.99	169,229.63
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,802.90	119,719.40	31,916.50
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,098.97	93,947.39	(34,151.59)
Хангамж, бараа материалын зардал	5,958.10	15,867.54	9,909.44
Нормативт зардал	65.30	176.50	111.20
Эд хогшил, урсгал засварын зардал	2,148.50	2,588.50	440.00
Томилолт, зочны зардал	144.30	94.60	(49.70)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,590.10	1,143.00	(4,447.10)
Бараа үйлчилгээний бусад зардал	111,667.57	120,886.63	9,219.05
Нийт дүн	1,063,028.11	1,245,205.55	182,177.44

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,200,489.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,158,203.5 мянган төгрөг буюу 96.48 хувьтай байгаа нь Ковидтой холбоотой хөл хорионы үеэр сургуулиуд цахимаар хичээллэсэн тул байр, ашиглалтын зардал багасаж хэмнэлт үүссэнээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд 41,188.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БСШУСЯ-наас VI-XII ангийн сурагчдын сурах бичгийг сургуулийн номын сангаар нь дамжуулан түрээсээр олгох шийдвэр гарсантай холбогдуулан тус сургуулийн нэмэлт дансанд эцэг эхчүүдээс 4,084.9 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлж, БСШУСЯамруу шилжүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл, иж

бүрэн бус мэдээлсэн 4 мэдээлэл байсан ба Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын шилэн дансанд хийсэн дотоод аудитын тайлангаар нийт 9 удаагийн 12,200.0 мянган төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Орхон аймгийн Төрийн аудитын албанаас 2019 онд хийсэн шалгалтаар “төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх” гэсэн зөвлөмжийг өгсөн ба 2020 онд өмнөх оны авлага өглөгийг барагдуулаагүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33,375.81 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,462.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,247.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 138.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,527.71 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн 4,084.9 мянган төгрөгийн номын түрээсийн орлогыг Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжээр бүртгэсэн, тодорхойгүй 378.0 мянган төгрөгийг Үр дүнгийн тайланд урсгал засварын зардлаар бүртгэсэн байсныг аудитын явцад залруулга хийсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төсөл хөтөлбөрт зориулсан 138.2 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, цай кофег аж ахуйн материал дансанд бүртгэсэн байна. Уг хүнсний бүтээгдэхүүн бодитоор байхгүй, шаардлагатай үед дэлгүүрээс авахаар мөнгийг шилжүүлсэн гэх боловч авлагын дансанд бүртгэлгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Аудитын явцад тус сургуулийн аж ахуйн материал болон тусгай зориулалтын материалд түүвэрлэн биет тооллогыг хийхэд анги танхимд байгаа 14 ширхэг ус шүүгч, 10 ширхэг шкаф биетээр байгаа боловч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ" гэсэн заалтуудтай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Нийт албан хаагчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхцуулан цалингийн зардлын хэмнэлтээс албан хаагч бүрд 193.0 мянган төгрөг, нийт 15,247.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн албаны тухай хуулийн 51.2-д "Энэ

хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн 20-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангаар төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг зөв тооцож олгож буй эсэх, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдаагүй биетээр оршин байгаа хөрөнгө байгаа эсэхийг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 1,146.6 мянган төгрөгийн авлага, 56.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.
2. Эрсдэл: Найдваргүй авлага үүсэх
3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтыг биелүүлж ажиллах.
4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн 20-р сургуулийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 31 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Зардлын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Бага ангийн багшийн 1 сарын цалинг тооцоолохдоо хуучин ажиллаж байсан цалингаар бодож цалингийн хүснэгт болон нийгмийн даатгалын тайлангийн цалин хоёрыг 124.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
2. Эрсдэл: Цалин, НДШ-ийн тооцоолол зөрүүтэй байх.
3. Өгсөн зөвлөмж: “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтын дагуу ажилчдын цалинг үнэн зөв тооцоолж, холбогдох тайлангуудтай тулган, тайлангуудын уялдаа холбоонд хяналт тавьж ажиллах.

4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн 20-р сургуулийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 31 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Шилэн данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 4 мэдээлэл байсан ба Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын шилэн дансанд хийсэн дотоод аудитын тайлангаар нийт 9 удаагийн 12,200.0 мянган төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна.
2. Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн ил тод байдал алдагдах
3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2-т “Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ” гэсэн заалтуудыг дагаж мөрдөж, мэдээллийг цаг хугацаандаа, үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших.

Орхон аймгийн 20-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн 20-р сургуулийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 31 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:	Аудитор		Б.Пүрэвсүрэн	Огноо
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Б.Эрдэнэ	Огноо
Хоёр дахь шатанд хянасан:	Дарга, тэргүүлэх аудитор		Л.Нармандах	Огноо

